ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Шилүүстэй сум Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/142/НА-СТА-ТШЗ

---

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

“Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох

Утас: 9904 2814

Цахим хаяг: buyanaa99042824@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
   2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
   2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
   2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
   2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
   2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга....8
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11
4. Аудитын тайлан....13
   4.1 Ерөнхий зүйл ....13
   4.2 Материаллаг байдал ....14
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт....14
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....14
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ....16
5. Аудитын илрүүлэлт ....16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.11 № 34

танай ______________-ны №______________-т

ШИЛҮҮСТЭЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Х.БАТДОРЖ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шилүүстэй сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шилүүстэй сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Шилүүстэй сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 45 арга хэмжээ төлөвлөснөөс 42 ажлыг 70-100 хувьтай хэрэгжүүлж, 2 ажил хэрэгжээгүй байна. Тайлант онд 1,655,271.0 мянган төгрөгийн санхүүжилттэй 84,055.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, цахим ангийн тоног төхөөрөмж, утасгүй интернет төхөөрөмжийн 72,844.4 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

Аудитын гол асуудал

Шилүүстэй сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар зөрчил илрээгүй бөгөөд өмнөх аудитаар өгсөн 3 заалт зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Шилүүстэй сумын Ерөнхий боловсрол нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны 05 дугаар сарын А/15 дугаар захирамжаар 123,032.3 мянган төгрөгийн үнэтэй Пургон автомашиныг 65,346.9 мянган төгрөгийн элэгдэлтэй балансаас балансд шилжүүлэн авч, бүртгэлд тусгасан байна.



812502068

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 145,592,044.75 | 183,511,258.26 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 51,937,463.41 | 84,055,523.92 |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | | |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 51,937,463.41 | 84,055,523.92 |
| 3121 | Төгрөг | 51,937,463.41 | 84,055,523.92 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 51,937,463.41 | 84,055,523.92 |
| 314 | Замд яваа мөнгөн хөрөнгө | | |
| 33 | АВЛАГА | 5,312,313.00 | |
| 335 | Бусад авлага | 5,312,313.00 | |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 5,312,313.00 | |
| 34 | УРЬДЧИЛГАА | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 88,342,268.34 | 99,455,734.34 |
| 351 | Түүхий эд материал | 8,895,214.00 | 10,819,325.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 8,415,214.00 | 10,539,325.00 |
| 3513 | Эм боох материал | 480,000.00 | 280,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 79,447,054.34 | 88,636,409.34 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 795,500.00 | 966,450.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 15,825,309.00 | 16,621,509.00 |
| 3545 | Барилгын засварын материал | 2,031,050.00 | 159,950.00 |
| 3546 | Хүнсний материал | 10,161,277.00 | 12,592,005.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 50,633,918.34 | 58,296,495.34 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | | |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,439,085,791.39 | 1,618,978,675.01 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,439,085,791.39 | 1,618,978,675.01 |
| 392 | Биет хөрөнгө | 1,387,692,791.39 | 1,567,833,175.01 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,553,618,145.00 | 1,565,003,145.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -305,490,950.48 | -375,496,356.92 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 5,000,000.00 | 128,032,325.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -4,999,999.80 | -82,650,134.28 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 241,382,922.21 | 460,806,329.21 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -165,869,625.36 | -201,378,499.08 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 104,575,534.83 | 115,435,534.83 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -62,792,014.89 | -69,566,448.67 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 6,368,280.00 | 8,168,280.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,069,279.86 | -6,115,279.82 |
| 39217 | Ном | 21,969,779.74 | 25,594,279.74 |
| 393 | Биет бус хөрөнгө | 51,393,000.00 | 51,145,500.00 |
| 39301 | Програм хангамж | 2,400,000.00 | 2,400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,905,000.00 | -2,152,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 50,898,000.00 | 50,898,000.00 |
| III | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,584,677,836.14** | **1,802,489,933.27** |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 72,844,431.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 72,844,431.00 |
| 413 | Өглөг | | 72,844,431.00 |
| 4136 | Бусад өглөг | | 72,844,431.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 72,844,431.00 |
| 414 | Урьдчилж орсон орлого | | |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | |
| 422 | Урт хугацаат зээл | | |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,584,677,836.14 | 1,729,645,502.27 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,584,677,836.14 | 1,729,645,502.27 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 454,572,294.10 | 454,572,294.10 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | | |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | | |
| 51101 | Өмч: - төрийн | 454,572,294.10 | 454,572,294.10 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 194,365,586.04 | 339,333,252.17 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 194,365,586.04 | 194,365,586.04 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 144,967,666.13 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 935,739,956.00 | 935,739,956.00 |
| VI | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,584,677,836.14** | **1,802,489,933.27** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *⁄төгрөгөөр⁄*

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,404,388,332.76 | 1,846,883,407.22 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 102,933,732.76 | 198,849,307.22 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 102,933,732.76 | 198,849,307.22 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,303,600.00 | 7,236,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,115,600.00 | 3,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 188,000.00 | 4,236,900.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 95,743,780.92 | 181,592,330.22 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 4,886,351.84 | 10,020,077.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,301,454,600.00 | 1,648,034,100.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,040,668,500.00 | 1,378,455,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,040,668,500.00 | 1,378,455,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 260,786,100.00 | 269,578,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 260,786,100.00 | 269,578,200.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |

| | | | |
|---|---|---|---|
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,312,468,586.10 | 1,701,915,741.09 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,312,468,586.10 | 1,701,915,741.09 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,280,251,730.39 | 1,672,511,422.09 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 788,474,304.62 | 1,057,151,367.63 |
| 210101 | Үндсэн цалин | 529,412,187.91 | 655,361,198.19 |
| 210102 | Нэмэгдэл | 216,697,354.22 | 346,418,863.94 |
| 210104 | Урамшуулал | 42,364,762.49 | 55,371,305.50 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 99,181,889.39 | 130,253,360.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,699,109.93 | 88,909,072.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,964,699.37 | 10,450,484.91 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,371,454.43 | 5,225,242.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,558,981.92 | 5,136,258.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,587,643.74 | 20,532,301.90 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 223,421,729.29 | 265,578,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,127,009.29 | 9,360,604.17 |
| 210302 | Түлш, халаалт | 213,174,720.00 | 254,567,595.83 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,120,000.00 | 1,650,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,187,806.00 | 19,817,938.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,463,700.00 | 1,810,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,341,576.00 | 9,238,888.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,135,000.00 | 2,535,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 480,000.00 | 350,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,767,530.00 | 5,883,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 33,624,358.00 | 32,057,352.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 160,750.00 | 200,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,463,608.00 | 31,857,352.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,968,950.00 | 16,294,950.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,968,950.00 | 16,294,950.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 3,877,400.00 | 4,536,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,877,400.00 | 4,536,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,115,600.00 | 9,559,357.54 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,115,600.00 | 1,657,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 7,901,457.54 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 109,399,693.09 | 137,262,196.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,464,200.00 | 3,118,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,051,622.24 | 9,258,750.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 95,883,870.85 | 124,885,446.60 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 32,216,855.71 | 29,404,319.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 29,889,762.00 | 29,404,319.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 29,889,762.00 | 29,404,319.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,327,093.71 | |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 2,327,093.71 | |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 91,919,746.66 | 144,967,666.13 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 337,500.00 | |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | 337,500.00 | |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -337,500.00 | |
| **V** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **91,582,246.66** | **144,967,666.13** |

**2.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *(төгрөгөөр)*

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,303,758,200.00 | 1,655,271,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,303,600.00 | 7,236,900.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,303,600.00 | 7,236,900.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,303,600.00 | 7,236,900.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,115,600.00 | 3,000,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 188,000.00 | 4,236,900.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,301,454,600.00 | 1,648,034,100.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,040,668,500.00 | 1,378,455,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,040,668,500.00 | 1,378,455,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 260,786,100.00 | 269,578,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 260,786,100.00 | 269,578,200.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,261,843,222.01 | 1,576,972,683.49 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,261,843,222.01 | 1,576,972,683.49 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,224,627,088.30 | 1,545,444,253.49 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 788,474,304.62 | 1,057,151,367.63 |
| 210101 | Үндсэн цалин | 529,412,187.91 | 655,361,198.19 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 216,697,354.22 | 346,418,863.94 |
| 210104 | Урамшуулал | 42,364,762.49 | 55,371,305.50 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 99,181,889.39 | 130,253,360.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,699,109.93 | 88,909,072.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,964,699.37 | 10,450,484.91 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,371,454.43 | 5,225,242.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,558,981.92 | 5,136,258.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,587,643.74 | 20,532,301.90 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 254,459,006.29 | 265,578,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,127,009.29 | 9,360,604.17 |
| 210302 | Түлш, халаалт | 244,211,997.00 | 254,567,595.83 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,120,000.00 | 1,650,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | |
| 2105 | Нормативт зардал | 39,748,409.00 | 34,288,080.00 |
| 210502 | Хоол, хүнс | 39,748,409.00 | 34,288,080.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,380,600.00 | 13,223,357.54 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,115,600.00 | 3,136,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,265,000.00 | 10,086,457.54 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,382,879.00 | 40,949,888.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,440,779.00 | 31,740,988.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,942,100.00 | 9,208,900.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 37,216,133.71 | 31,528,430.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 34,889,040.00 | 31,528,430.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 34,889,040.00 | 31,528,430.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,327,093.71 | |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 2,327,093.71 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 41,914,977.99 | 78,298,316.51 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| IV | | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | | |
| V | | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 20,313,000.00 | 46,180,256.00 |
| | | Дотоод эх үүсвэрээр | 20,313,000.00 | 46,180,256.00 |
| | 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 20,313,000.00 | 46,180,256.00 |
| VI | | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -20,313,000.00 | -46,180,256.00 |
| | 145 | Бусад эх үүсвэр | | |
| | 25 | Санхүүгийн үйл ажиллагааны зардал | | |
| VII | | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| VIII | | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 21,601,977.99 | 32,118,060.51 |
| | 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 51,937,463.41 |
| | 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 84,055,523.92 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | | |
| 9 | ................ | | | | |
| 10 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 454,572,294.10 | 935,739,956.00 | 194,365,586.04 | 1,584,677,836.14 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 13 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 14 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| 15 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| 16 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 144,967,666.13 | 144,967,666.13 |
| 18 | ................ | | | | |
| 19 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 454,572,294.10 | 935,739,956.00 | 339,333,252.17 | 1,729,645,502.27 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* */төгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,703,000,600.00 | 1,623,152,939.49 | 79,847,660.51 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,703,000,600.00 | 1,576,972,683.49 | 126,027,916.51 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,671,471,900.00 | 1,545,444,253.49 | 126,027,646.51 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,089,955,100.00 | 1,057,151,367.63 | 32,803,732.37 |
| 210101 | Үндсэн цалин | 749,886,000.00 | 655,361,198.19 | 94,524,801.81 |
| 210102 | Нэмэгдэл | 298,649,600.00 | 346,418,863.94 | -47,769,263.94 |
| 210104 | Урамшуулал | 41,419,500.00 | 55,371,305.50 | -13,951,805.50 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 136,244,400.00 | 130,253,360.32 | 5,991,039.68 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 92,646,300.00 | 88,909,072.51 | 3,737,227.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,899,600.00 | 10,450,484.91 | 449,115.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,449,700.00 | 5,225,242.51 | 224,457.49 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,449,700.00 | 5,136,258.49 | 313,441.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,799,100.00 | 20,532,301.90 | 1,266,798.10 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 265,578,000.00 | 265,578,200.00 | -200 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,814,400.00 | 9,360,604.17 | 1,453,795.83 |
| 210302 | Түлш, халаалт | 252,963,600.00 | 254,567,595.83 | -1,603,995.83 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,650,000.00 | 150,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | | |
| 2105 | Нормативт зардал | 71,429,900.00 | 34,288,080.00 | 37,141,820.00 |
| 210502 | Хоол, хүнс | 71,429,900.00 | 34,288,080.00 | 37,141,820.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,000,000.00 | 4,000,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 4,000,000.00 | |
| 2107 | Томилолт, зочны зардал | | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 20,340,400.00 | 13,223,357.54 | 7,117,042.46 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 3,136,900.00 | -3,136,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 20,340,400.00 | 10,086,457.54 | 10,253,942.46 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 83,924,100.00 | 40,949,888.00 | 42,974,212.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 74,715,200.00 | 31,740,988.00 | 42,974,212.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,208,900.00 | 9,208,900.00 | |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 31,528,700.00 | 31,528,430.00 | 270 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 31,528,700.00 | 31,528,430.00 | 270 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 31,528,700.00 | 31,528,430.00 | 270 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 46,180,256.00 | -46,180,256.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | | 46,180,256.00 | -46,180,256.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,713,374,600.00 | 1,655,271,000.00 | 58,103,600.00 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,436,559,500.00 | 1,378,455,900.00 | 58,103,600.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,436,559,500.00 | 1,378,455,900.00 | 58,103,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 269,578,200.00 | 269,578,200.00 | |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 269,578,200.00 | 269,578,200.00 | |
| 133 | ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС | | | |
| 134 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 7,236,900.00 | 7,236,900.00 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,000,000.00 | 3,000,000.00 | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,236,900.00 | 4,236,900.00 | |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 51,937,463.41 | -51,937,463.41 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 84,055,523.92 | -84,055,523.92 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31*

*/төгрөгөөр/*

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | **1220** | Тусламжийн орлого | 269,578,200.00 | 269,578,200.00 | | 100 |
| 3 | 122005 | Төсвөөс санхүүжих | 269,578,200.00 | 269,578,200.00 | | 100 |
| 4 | **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 265,578,200.00 | 265,578,200.00 | | 100 |
| 5 | 210301 | Гэрэл, цахилгаан | 10,814,600.00 | 9,360,604.17 | 1,453,995.83 | 86.56 |
| 6 | 210302 | Түлш, халаалт | 252,963,600.00 | 254,567,595.83 | -1,603,995.83 | 100.63 |
| 7 | 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,650,000.00 | 150,000.00 | 91.67 |
| 8 | **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,000,000.00 | 4,000,000.00 | | 100 |
| 9 | 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 4,000,000.00 | | 100 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэл:***

- *Ерөнхий боловсрол олгох*

***Ерөнхий боловсролын сургуулийн зорилго:***

Ээлжит хичээлийн чанар өгөөжийг нэмэгдүүлсэнээр суралцахуйн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд дараах зорилтыг тавин ажиллаж байна. Үүнд:
Зорилт-1: Pearson eduten хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлнэ
Зорилт-2: Багш бүр сургалтын бүтээлч аргуудаас сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж үр дүн тооцно
Зорилт-3: ЗАН-ийн бүтээлч оролцоог нэмэгдүүлнэ.
Зорилт-4: олон нийтийн оролцоонд тулгуурлан сурах сургах үйлийг дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулж байгууллагын зэрэг уур амьсгал соёлыг төлөвшүүлнэ.
Зорилт-5: Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах хувийг нэмэгдүүлнэ
Зорилт-6: Сургуулийн орчин дахь хүүхэд хамгаалал аюулгүй байдлыг хангана
Зорилт-7: Өдөр бүр сүү арга хэмжээг хэрэгжүүлнэ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Боловсролын тухай хууль
4. Төсвийн тухай хууль
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын ерөнхий хууль

7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Бага дунд боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд ЕБС-ын захирал, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шилүүстэй сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 179,892.8 мянган төгрөгөөр өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 5,312.3 | 00.00 | -5,312.3 |
| Бараа материал | 88,342,2 | 99,455.7 | 11,114.5 |
| Үндсэн хөрөнгө | 1,439,085.7 | 1,618,978.6 | 179,892.8 |
| **Нийт хөрөнгө** | **1,584,677,8** | **1,802,489,9** | **217,812.1** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,584,677.8 | 1,729,645.5 | 144,967.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,584,677,8** | **1,802,489,9** | **217,812.1** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлагын эхний үлдэгдэл 5,312.3 мянган төгрөг, тайлант онд 109,763.0 мянган төгрөгийн авлага барагдаж, 104,450.7 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, эцсийн үлдэгдэл 00.00 мянган төгрөг болсон байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 88,342.2 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 105,041.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүйгээр 10,020.00 нэмэгдэж, 103,948,3 мянган төгрөгийн бараа материал зарцуулан , эцсийн үлдэгдэл 99,455,7 мянган төгрөг болж, өмнөх оноос 11,114.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 123,186.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 123,906.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, жилийн эцэст 1,618,978.. мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 124,885.4 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 144,967.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсөв болон орон нутгийн төсвөөс 1,713,374.6 мянган төгрөг, нийт зарлагыг 1,713,374.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тодотголоор нэмж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,623,152.9 мянган төгрөг буюу 95.31 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон дотуур байрын хүүхдийн хоолны мөнгө хэмнэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| 80109 | **Тогтмол зардал** | **269,578.3** | **269,578.2** | | 100 |
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| 80226 | Байр ашиглалтын үйлчилгээ | 2,254.4 | 2,254.4 | | 100 |
| 80233 | Хүүхэд хамгаалал | 2,383.0 | 2,383.0 | | 100 |
| 80312 | Сургалт семинар | 1,631.4 | 1,622.9 | | 99.48 |
| 81605 | Эрүүл мэндийг дэмжих | 2,738,7 | 1,948,1 | | 71.1 |
| 81801 | Үдийн цай хөтөлбөр | 31,528.7 | 31,528.4 | | 100 |
| 81806 | Дотуур байрын хүүхдийн хоол | 221,594.7 | 206,320.3 | 42,791.4 | 78 |
| 81816 | Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр | 37,149.5 | 37,310.4 | | 100 |
| 81823 | Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 6,763.0 | 3,509.7 | 3,253.2 | 52 |
| 81827 | Бичиг үсгийн боловсрол | 11,922.1 | 1,423.7 | 12,335.7 | 9.9 |
| 81834 | Боловсролын стандарт төлөвлөгөө хөтөлбөр | 1,016,013.8 | 994,669.8 | 21,460.9 | 95 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 43,423.3 | 43423.3 | | 100 |
| 81844 | Төрөлжсөн сургалтын орчин | 1,100.00 | 1,100.0 | | 100 |
| 81848 | Сурах бичгийн түрээс | 3,136.9 | 3,136.9 | | 100 |
| 81875 | Сургуулийн нэмэлт хөтөлбөр | 1,383.5 | 1,383.5 | | 100 |
| 83603 | Дээд шатны төсвөөс хуваарилсан | 3,000.0 | 3,000.0 | | 100 |
| **НИЙТ** | | **1,703,000.6** | **1,623,152.9** | **79,847.6** | **95.3** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71802 | Ерөнхий боловсрол | | | | |
| 80109 | ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал | 269,578.2 | 269,578.2 | 0 | 100 |
| **НИЙТ** | | **269,578.2** | **269,578.2** | **0** | **100** |

Орон нутгын санхүүжилтээр 269,578.2 мянган төгрөгийн тогтмол зардал төвлөрүүлж, батлагдсан төсвийн дагуу 269,578.2 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Нээлттэй тендер шалгаруулалт | Дотуур байрын хүүхддийн хоол хүнс худалдан авах | 64,822.0 | 13,025.4 |
| 2 | Нээттэй тендер шалгаруулалт | Үдийн хоолны хүнсний материал худалдан авах | 29,376.0 | 11,931.0 |
| **ДҮН** | | | **94,198.00** | **24,956.4** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Шилүүстэй сумын Ерөнхий болосролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Хаан соёмбо аудит" ХХК-ийн гэрээт аудитор Ж.Буянтогтох гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн анхан шатанд хянаж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Шилүүстэй сумын Ерөнхий болосролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 84 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны орлогын 1,404,388,3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14,043.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11,235.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны орлогын 1,846,883.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 18,468.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14,775.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар томилолт илүү олгосон, хоолны зардлыг нормативаас 449.5 мянган төгрөгөөр илүү зарцуулсан зөрчилд 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж зөвлөмжийн хариуг ирүүлсэн байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт,албан шаардлага,зөвлөмжгүй ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | | | | | |
| **Нийт дүн** | | | | | |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илэрээгүй байна.

***Залруулсан алдаа:*** *Залруулсан алдаа байхгүй*

**5.1 Төлбөрийн акт тогтоогдоогүй**

**5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

**5.3 Зөвлөмж өгөгдөөгүй**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-24

**БОЛОВСРУУЛСАН:**

ГЭРЭЭТ АУДИТОР “ХААН СОЁМБО АУДИТ” ХХК-ИЙН Ж.БУЯНТОГТОХ

Огноо: 2025-02-24